



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2013 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 444

Улаанбаатар хот

“Компанийн засаглалын чиглэлээр сургалт явуулах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалт, Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн дүрмийн 2.1.1.2, 4.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 332 дугаар тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын чиглэлээр сургалт явуулах журам”-д дор дурдсан агуулга бүхий 2 дугаар зүйлийн 2.6, 2.7 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.6 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2, 4.3 дахь хэсгүүдийг тус тус нэмсүгэй:

1/ 2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 6, 7 дахь заалтууд:

“2.6. Гурваас доошгүй тооны үндсэн гэрээт сургагч багштай байх ба тэдгээр нь компанийн засаглалын сургалтын бусад байгууллагад давхар үндсэн гэрээт багшаар ажиллаагүй байна.

2.7. Байгууллагын бизнесийн ёс зүйг хангаж ажиллах.”

2/ 3 дугаар зүйлийн 6 дахь заалт:

“3.6. Сургалтын байгууллага нь онлайн хэлбэрээр сургалт зохион байгуулах тохиолдолд онлайн сургалтын хөтөлбөрийн төслийг боловсруулан зөвлөлд танилцуулж Хорооны хурлаар батлуулсан байна.”

3/ 4 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь заалтууд:

“4.1. Гадаадын хөрөнгө оруулалттай компанийн гадаадын харьяалалтай төлөөлөн удирдах зөвлөлийн /цаашид ТУЗ гэх/ гишүүн нь Компанийн тухай хуулийн 75.8 дах заалтыг хангасан байна.

4.2. Гадаадын харьяалалтай ТУЗ-ийн гишүүн нь Монгол улсын нутаг дэвсгэрт зохион явуулж буй сургалтад өөрийн биеэр хамрагдах боломжгүй тохиолдолд онлайн сургалтад хамрагдаж болно.

4.3. Олон улсын хэмжээний компанийн засаглалын сургалтад өмнө нь хамрагдаж гэрчилгээ авсан гадаадын харьяалалтай ТУЗ-ийн гишүүний хувьд Монгол улсын хууль тогтоомжийн талаар

030801

мэдлэг олгох тусгайлан боловсруулсан сургалтын хөтөлбөрийн дагуу танхим эсхүл онлайн сургалтад хамрагдаж болно.”

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 332 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан “Компанийн засаглалын чиглэлээр сургалт явуулах журам”-ын дөрөвдүгээр зүйлийн “Дөрөв” гэснийг “Тав” гэж өөрчилсүгэй.

3. Журамд нэмэлт, өөрчлөлтийг оруулж хэрэгжилтийг ханган, хяналт тавьж ажиллахыг Компанийн засаглалын үндэсний зөвлөл /Д.Ганбаяр/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 11 дугаар сарын 20-ны 474/тогтоолын хавсралт

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР СУРГАЛТ ЯВУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл



1.1. Энэ журмаар компанийн засаглалын чиглэлээр сургалт явуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Компанийн засаглалын чиглэлээр явуулах сургалт /цаашид “сургалт гэх”/-ыг энэ журмын дагуу компанийн засаглалын чиглэлээр сургалт явуулах эрх авсан сургалтын байгууллага /цаашид “Сургалтын байгууллага” гэх/ явуулна.

1.3. Сургалтын байгууллага нь журмын нэгдүгээр хавсралтад заасан сургалтын хөтөлбөрийн дагуу компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, нарийн бичгийн даргад компанийн засаглалын чиглэлээр үндсэн мэдлэг олгох сургалт явуулна.

Хоёр. Сургалт явуулах эрх олгох, сургалтын байгууллагад тавигдах шаардлага

2.1. Компанийн засаглалын үндэсний зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ нь компанийн засаглалын чиглэлээр сургалт явуулах эрх олгоно.

2.2. Зөвлөлийн дарга компанийн засаглалын чиглэлээр сургалт явуулах эрх авсан сургалтын байгууллагатай “Сургалт зохион байгуулах гэрээ” байгуулна.

2.3. Сургалтын байгууллага нь дараах шаардлага, нөхцөлийг хангасан байна:

2.3.1. Сургалт явуулах зориулалтын байртай байх;

2.3.2. Сургалтын тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон байх;

2.3.3. Сурах бичиг, гарын авлага, тестийн материалаар хангагдсан байх;

2.3.4. Хорооноос баталсан сургалтын хөтөлбөрийг үндэслэн өөрсдийн сургалтын хөтөлбөрийг боловруулсан байх;

2.3.5. Сургалтын багш нь сургагч багшийн сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх;

2.3.6. Гурваас доошгүй тооны үндсэн гэрээт сургагч багштай байх ба тэдгээр нь компанийн засаглалын сургалтын бусад байгууллагад давхар үндсэн гэрээт багшаар ажиллаагүй байна ;

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 11 сарын 20 өдрийн 474 дүгээр тогтоолоор нэмсэн/

2.3.7. Байгууллагын бизнесийн ёс зүйг хангаж ажиллах.

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 11 сарын 20 өдрийн 474 дүгээр тогтоолоор нэмсэн/

2.4. Сургалтын байгууллага нь компанийн засаглалын чиглэлээр сургалт явуулах эрх авах хүсэлт гаргахдаа дор дурьдсан баримт бичгийг Зөвлөлийн Ажлын албанд ирүүлнэ:

- 2.4.1. Сургалт явуулах хүсэлт;
- 2.4.2. Улсын бүртгэл болон сургалтын үйл ажиллагааны эрхийн гэрчилгээний хуулбар;
- 2.4.3. Сургалтын байгууллагын дүрмийн хуулбар;
- 2.4.4. Сургалтын хөтөлбөрийн хуулбар;
- 2.4.5. Багшийн анкет;
- 2.4.6. Байгууллагын дэлгэрэнгүй танилцуулга;
- 2.4.7. Сургалт явуулах анги танхим, тоног төхөөрөмжийн талаар мэдээлэл болон тэдгээрийн фото зураг;

Гурав. Сургалт явуулах, гэрчилгээ олгох

3.1. Сургалтыг чанартай, үр дүнтэй явуулах үүднээс тухайн сургалтын байгууллагын сургалт зохион байгуулах байр, багш нарын чадавхыг харгалзан нэг анги дүүргэлтийн дээд хэмжээг “Сургалт зохион байгуулах гэрээ”-нд тусгана.

3.2. Сургалтын байгууллага нь сургалт зохион байгуулах зориулалтын байранд сургалт явуулах бөгөөд сургалтын багц цагийн тодорхой хэсэгт онлайн сургалтын аргыг хэрэглэж болно.

3.3. Сургалтын байгууллага нь сургалтын жилийн төлөвлөгөөг баталж, олон нийтэд мэдээлнэ.

3.4. Сургалтын байгууллага нь сургалтын хөтөлбөрт бүрэн хамрагдсан этгээдээс шалгалт авна.

3.5. Компанийн засаглалын үндэсний зөвлөл нь сургалтын байгууллагаас ирүүлсэн мэдээллийг үндэслэн сургалтад бүрэн хамрагдаж, шалгалтад тэнцсэн сурагчдад компанийн засаглалын чиглэлээр сургалтад амжилттай хамрагдсаныг нотлох нэгдсэн дугаартай хавсралт хоёрт заасан загвар бүхий гэрчилгээ /цаашид “гэрчилгээ” гэх/ олгоно.

3.6. Сургалтын байгууллага нь онлайн хэлбэрээр сургалт зохион байгуулах тохиолдолд онлайн сургалтын хөтөлбөрийн төслийг боловсруулан зөвлөлд танилцуулж Хорооны хурлаар батлуулсан байна.

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 11 сарын 20 өдрийн 474 дүгээр тогтоолоор нэмсэн/

Дөрөв. Гадаадын хөрөнгө оруулалттай компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гадаадын харьяалалтай гишүүдэд сургалт явуулах

4.1. Гадаадын хөрөнгө оруулалттай компанийн гадаадын харьяалалтай төлөөлөн удирдах зөвлөлийн /цаашид ТУЗ гэх/ гишүүн нь Компанийн тухай хуулийн 75.8 дах заалтыг хангасан байна.

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 11 сарын 20 өдрийн 474 дүгээр тогтоолоор нэмсэн/

4.2. Гадаадын харьяалалтай ТУЗ-ийн гишүүн нь Монгол улсын нутаг дэвсгэрт зохион явуулж буй сургалтад өөрийн биеэр хамрагдах боломжгүй тохиолдолд онлайн сургалтад хамрагдаж болно.

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 11 сарын 20 өдрийн 474 дүгээр тогтоолоор нэмсэн/

4.3. Олон улсын хэмжээний компанийн засаглалын сургалтад өмнө нь хамрагдаж гэрчилгээ авсан гадаадын харьяалалтай ТУЗ-ийн гишүүний хувьд Монгол улсын хууль тогтоомжийн талаар мэдлэг олгох тусгайлан боловсруулсан сургалтын хөтөлбөрийн дагуу танхим эсхүл онлайн сургалтад хамрагдаж болно.

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 11 сарын 20 өдрийн 474 дүгээр тогтоолоор нэмсэн/

Тав. Хариуцлага

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 11 сарын 20 өдрийн 474 дүгээр тогтоолоор өөрчилсөн/

5.1. Зөвлөл нь энэ журам болон “Сургалт зохион байгуулах гэрээ”-г зөрчсөн сургалтын байгууллагын компанийн засаглалын чиглэлээр сургалт зохион байгуулах эрхийг хүчингүй болгож, олон нийтэд мэдээлэх бөгөөд 1 жилийн хугацаанд тус сургалтын байгууллагад сургалт зохион байгуулах эрх олгохгүй.

--- оОо---

БАТЛАВ:

**КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Д.ГАНБАЯР**

**Компанийн засаглалын гэрчилгээ олгох
сургалтын хөтөлбөр**

Компанийн засаглалын гэрчилгээ олгох сургалт нь ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн дарга нарт удирдлагын ур чадваруудыг олгох зорилготой бөгөөд үйл ажиллагаанаас илүүтэйгээр стратегийн болон хэтийн зорилгод чиглэсэн агуулгатай байна. Энэхүү сургалтад хамрагдсанаар гэрчилгээ олгогдоно.

Оролцогчид:

Тус сургалтад компанийн ТУЗ-ийн гишүүд, захирлууд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга зэрэг хуулийн этгээдээс илгээсэн ажилтан, гүйцэтгэх удирдлага, хариуцлагатай ажилтан, хувь хүмүүс хамрагдана.

Сургалтын агуулга:

Сургалтаар ТУЗ-ийн үйл ажиллагааг үр өгөөжтэй удирдах, захирлуудын цалин урамшууллын бодлого болон гүйцэтгэх удирдлагыг хянах оновчтой тогтолцоо, хууль эрх зүйн хүрээнд мэдээллийн нээлттэй байдлыг ханган ажиллах, сонирхлын зөрчилтэй гэрээ хэлцлүүд ба нэгдмэл сонирхолтой этгээдийн асуудлууд, эрсдэлийн удирдлага болон манлайлал зэрэг компанийн засаглалын ойлголтуудыг нарийвчлан авч үзнэ.

Сургалтад хамрагдсанаар:

- Компанийн засаглалын ач холбогдол дэлхийн шилдэг туршлагауд,
- Монголын хууль эрх зүйн зохицуулалт, OECD-ийн зарчмуудад нийцсэн компанийн засаглалын тогтолцоог өөрийн компанидаа бий болгох арга зам,
- Хараат бус, гүйцэтгэх бус захирлуудын үүрэг ач холбогдол, захирлуудыг сонгон шалгаруулах үйл явц, ТУЗ-ийн дарга ба гүйцэтгэх удирдлагыг салгах, ТУЗ-ийн хараат бус байдал,
- Хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн гишүүд ба гүйцэтгэх удирдлага, бусад оролцогч талуудын компанийн засаглал дахь үүрэг хариуцлага,

- ТУЗ-ийн эрх мэдлийн хүрээ, гүйцэтгэх удирдлагыг чиглүүлэх, стратегийг батлах үүргүүд,
- Дотоод гадаад хяналт, мэдээллийн нээлттэй байдлыг ханган ажилласнаар ТУЗ хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах,
- ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үүргүүд ба хурлыг үр дүнтэй хэрхэн зохион байгуулах аргуудад суралцана.

Сургалтын бүтэц:

Сургалтын хөтөлбөр нийт 14 сэдвээс бүрдэх бөгөөд 4 өдөр үргэлжилнэ. Хөтөлбөрийг хувь хүний шаардлага нөхцөлд тааруулан уян хатан зохион байгуулах үүднээс анхан шатны, ахисан түвшний сургалт гэж ангилсан. Анхан шатны сургалтад хамрагдсан бол ахисан түвшний сургалтад цааш суралцах боломжтой ба ахисан түвшний сургалтад хамрагдаж шалгалт өгснөөр компанийн засаглалын гэрчилгээ олгогдоно.

- **Анхан шат:** 8 семинарыг дүүргэсэн байх ёстой бөгөөд Компанийн ТУЗ-ийн гишүүдийн /хараат бус гишүүд/ үүрэг, ТУЗ-ийн хороодын үйл ажиллагаа, гүйцэтгэх удирдлага, хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга сэдвийг агуулсан сургалтад заавал хамрагдсан байна. Ингэснээр дараагийн ахисан шатны сургалтад хамрагдах нөхцөл бүрдэнэ.
- **Ахисан түвшин:** 7 семинар дүүргэсэн байх бөгөөд Анхан шатны сургалтад заавал хамрагдсан байна. Тайлагнал ба ил тод байдал, их хэмжээний хэлцэл, санхүү, эрсдэлийн удирдлага, хөндлөнгийн аудит, компанийн нийгмийн хариуцлага сэдвийг агуулсан сургалтад заавал хамрагдсан байна. Ингэснээр компанийн ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн дарга нарт зориулсан гэрчилгээний шаардлагыг хангана.

Хэл: Семинарууд монгол эсвэл англи хэл дээр явагдаж болно. Англи хэл дээр явагдах тохиолдолд орчуулгатай явагдах ба сургалтын материал нь англи, монгол хэл дээр давхар байна.

Сургалт интерактив байдлаар оролцогчдын асуулт хариулт, кейс сургалт, харилцан бие биенийхээ туршлагаас суралцах боломжийг дэмжих аргаар явагдана.

Хөтөлбөр:

| Хугацаа | Өдөр 1 | Өдөр 2 | Өдөр 3 | Өдөр 4 |
|-----------------|--|----------------------------|---|--------------------------------|
| Сургалтын төрөл | Анхан шат | | Ахисан түвшин | |
| 2 цаг | Компанийн засаглалын танилцуулга | ТУЗ-ийн Хороод | Тайлагнал болон ил тод байдал | Эрсдэлийн удирдлага |
| 2 цаг | Төлөөлөн удирдах зөвлөл | Гүйцэтгэх удирдлага | Санхүүгийн бус ТУЗ-ийн гишүүдэд зориулсан санхүүгийн сургалт | Хөндлөнгийн болон дотоод аудит |
| 2 цаг | Компанийн засаглалын хууль эрх зүйн орчин | Хувьцаа эзэмшигчид | Санхүүгийн бус ТУЗ-ийн гишүүдэд зориулсан санхүүгийн сургалт | Компанийн нийгмийн хариуцлага |
| 2 цаг | Хараат бус, гүйцэтгэх болон гүйцэтгэх бус ТУЗ-ийн гишүүд | ТУЗ-ийн нарийн бичиг дарга | Тусгай сэдэв: Их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчилтэй хэлцэл | Тест болон багшийн үнэлгээ |

Дээрх хөтөлбөр нь дараах агуулгатай байна. Үүнд:

Компанийн засаглалын танилцуулга:

Компанийн засаглал гэж юу вэ, компанийн засаглалын үндсэн болон бусад оролцогч талууд, эзэн, төлөөлөгчийн зөрчил болон үүнээс үүдэх зардал, сайн компанийн засаглалын ач холбогдол.

Төлөөлөн удирдах зөвлөл:

ТУЗ-ийн үүрэг, хариуцлага, ТУЗ болон гүйцэтгэх удирдлага, хувьцаа эзэмшигчдийн ажлын уялдаа холбоо, ТУЗ-ийн төрөл, бүтэц бүрэлдэхүүн, ТУЗ-ийн дарга

болон гүйцэтгэх захирлын албан тушаалд нэг хүн ажиллахгүй байх зарчим, ТУЗ-ийн үндсэн үүргүүд.

Компанийн засаглалын хууль эрх зүйн орчин:

Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, ОУХАХБ-ийн Компанийн засаглалын зарчмууд (2004).

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд, гүйцэтгэх болон гүйцэтгэх бус гишүүд:

Хараат бус гишүүд, гүйцэтгэх болон гүйцэтгэх бус гишүүдийн тодорхойлолт, тэдний үүрэг хариуцлага. ТУЗ-ийн гишүүдийн хариуцлагын даатгал. Хараат бус гишүүдийн хувийн болон мэргэжлийн зан чанар.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хороод:

Аудит, цалин урамшууллын, нэр дэвшүүлэх хороод болон ТУЗ-ийн бусад хороод, эдгээр хороодын үүрэг хариуцлага, бүтэц бүрэлдэхүүн. Компанийн тухайн хуулийн дагуу Аудит, цалин урамшууллын, нэр дэвшүүлэх хороодын чиг үүрэг.

Гүйцэтгэх удирдлага:

Гүйцэтгэх удирдлагын үүрэг хариуцлага: эрхэм зорилго, алсын хараа, стратеги. ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын үүрэг хариуцлагын ялгаа. Гүйцэтгэх удирдлагын томилгоо, цалин урамшуулал болон ирээдүйн гүйцэтгэх удирдлагыг бэлтгэх ТУЗ-ийн чиг үүрэг.

Хувьцаа эзэмшигчид:

Хувьцаа эзэмшигчдийн төрөл, тэдний эрх үүрэг. ТУЗ-ийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах чиг үүрэг, хувьцаа эзэмшигчдийн идэвх.

Тайлагнал болон ил тод байдал:

Тайлагнал болон ил тод байдал гэдэгт юуг ойлгох, компаниуд юуг тайлагнах. ОУХАХБ-ийн Компанийн засаглалын зарчмуудад тусгагдсан тайлагнал болон ил тод байдлын талаарх шаардлага. Тайлагнал болон ил тод байдлын компанийн засаглалын уялдаа холбоо.

Санхүүгийн бус ТУЗ-ийн гишүүдэд зориулсан санхүүгийн сургалт:

ТУЗ-ийн санхүүжилт, хөрөнгө оруулалт болон ноогдол ашгийн талаарх шийдвэрүүд. Санхүүгийн тайлан болон санхүүгийн харьцаанууд. Санхүүжилт, хөрөнгө оруулалт болон ноогдол ашгийн шийдвэр баялгийг хэрхэн бүтээж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг нэмэгдүүлдэг тухай.

Их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчилтэй хэлцэл:

Их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтэй хэлцэл гэж ямар хэлцлийг хэлцлийг ойлгох тухай, Компанийн тухай хуулийн зохицуулалтын өнөөгийн байдал, ТУЗ-ийн гишүүд, хараат бус гишүүд эдгээр хэлцлийг хянах үүргийн тухай.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга:

ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үүрэг, хариуцлага, эрх мэдлийн хүрээ, ТУЗ-ийн хурал ба хувьцаа эзэмшигчдийг хурлыг зохион байгуулахад нарийн бичгийн даргын үүрэг, компанийн засаглалын бусад эрх үүргүүдийг авч үзэх.

Эрсдэлийн удирдлага:

COSO эрсдэлийн удирдлага, ТУЗ-ийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд гүйцэтгэх үүрэг, гүйцэтгэх удирдлагын гүйцэтгэх үүрэг.

Хөндлөнгийн аудит болон дотоод аудит:

Хөндлөнгийн аудит болон дотоод аудит гүйцэтгэхэд ТУЗ-ийн гүйцэтгэх үүрэг, хөндлөнгийн аудит болон дотоод аудит засаглалыг сайжруулахад гүйцэтгэх үүрэг, эрсдэлийн удирдлагатай ямар холбоотой тухай. Аудитын хорооны гүйцэтгэх үүрэг.

Компанийн нийгмийн хариуцлага:

Компанийн нийгмийн хариуцлага гэж юуг ойлгох, компанийн оролцогч талууд болон тэдний сонирхол, компанийн нийгмийн хариуцлагын шүүмжлэл, компанийн нийгмийн хариуцлагын талаарх онолууд.

Жич: Энэхүү сургалтад хамрагдсанаас хойш 2 жилийн хугацаанд ямар нэгэн компанийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаагүй тохиолдолд дахин сургалтад хамрагдах шаардлагатай. Түүнчлэн ТУЗ-ийн гишүүн болсноос хойш хагас жилийн дотор дахин ахисан түвшний сургалтад хамрагдаж сургалтын гэрчилгээг авсан байна. Ахисан түвшний сургалтад хамрагдалгүйгээр бие даан суралцаж шалгалт өгч болно.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ



Сургалтын
байгууллагын
лого

СЭХ ТҮТҮЛЭХ
ЭНЭЖИЛЭГЭЭ

Тусгаар

..... овогтой нь

Компанийн тухай хуулийн 75.8 дахь заалтыг үндэслэн

"Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга" нэрт зориулсан

Компанийн засаглалын 36 цэвийн сурвалтанд хамрагдсан тул гэрчилгээ олгог.

Гарын үсэг

Гарын үсэг

201... оны ... р сарын ... өдөр